



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Тендерийн жишиг баримт
бичиг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Барааны үнийн санал авах тендерийн жишиг баримт бичиг"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Ажлын үнийн санал авах тендерийн жишиг баримт бичиг"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх үед үнийн санал авах баримт бичгийг боловсруулж ажиллахыг Захиалагч нарт даалгасугай.

Гурав. Захиалагч байгууллагуудыг энэхүү баримт бичгийг ашиглахад шаардлагатай мэргэжилт, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/-д тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2007 оны 268 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УЛААН

000334

Сангийн сайдын 2013 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 125 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
Ц.ӨНӨРЖАРГАЛ
ДАРГА
2019 оны 05 сарын 24 өдөр

[ӨМНӨГОВЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР]

**[ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ХЭРЭГСЭЛ] НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**“СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД
ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ХЭРЭГСЭЛ
НИЙЛҮҮЛЭХ”**

Төслийн дугаар:

ӨМАЭМГ2019/02

[Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Өмнөговь аймгийн сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгсэл нийлүүлэх] ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-н хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим сиситем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn- ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***[2019 оны 06 сарын 04]***-ны өдрийн ***[10цаг 30 тинут]***¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. ***[тооцохгүй]***

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Өмнөговь аймаг Эрүүл Мэндийн Газар (1 давхар 115 тоот Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, хангамж хариуцсан мэргэжилтэн Д.Сэлэнгэ, утас:99729745 selenge.om@gmail.com)]

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн [2018 оны] жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт; 2. Бусад нэмэлт шаардлага; <ol style="list-style-type: none"> 1. Эм эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /эх хувиас/ 2. Сүүлийн 2 жилд Авилгын эсрэг, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, Эрүүгийн хууль зөрчөөгүй болохыг тодорхойлсон Шүүхийн тодорхойлолт 3. Монгол улсын хуулийн дагуу татвар хураамжаа бүрэн төлсөн тухай Татварын газрын тодорхойлолт /хугацаа хэтэрсэн өргүй байх/ 4. Сүүлийн 1 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй гэрээний мэдээлэл 5. Тендерт оролцогч барааг 100 хувь өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж бараа хүлээлцсэн баримт нэхэмжлэлийн дагуу сум өрхийн эрүүл мэндийн төвүүд байгуулсан гэрээний дагуу санхүүжилтыг олгоно. 6. Нийлүүлэх эм хэрэгсэл нь техникийн нөхцөлд заасан шаардлагыг хангасан байна 7. Бараа нийлүүлэх хугацаа нь тендерийн шалгуур үзүүлэлтийн нэг болно. 8. Харилцагч бүх банкний тодорхойлолт /хугацаа хэтэрсэн өргүй байх/ 9. Эм хэрэгсэл хүргэх эцсийн цэг нь Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар 1 давхар 115 тоот
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар 1 давхар 115тоот]</p> <p>Огноо: [2019 оны 06 дугаар сарын 04ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [багцгүй]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.Барааны тодорхойлолт:

1. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байх
 2. ДЭМБ-н эсвэл НҮБХАС-н урьдчилсан баталгаажуулалтад хамрагдсан байх, эсвэл эмнэлгийн хэрэгслийн хувьд хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй байх
 3. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон байх
 4. Эм үйлдвэрлэлийн зохистой дадалын /GMP/ шаардлагыг хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн
 5. Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан байх
 6. жирэмслэлтээс сэргийлэх эмийн хүчинтэй байх хугацаа нь нийлүүлэх үед 1,5 жилээс дээш хадгалах хугацаатай байх
- ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ХЭРЭГСЛИЙН ХУВЬД**
1. ДЭМБ-н эсвэл НҮБХАС-н урьдчилсан баталгаажуулалтын шаардлага хангасан, хатуу зохицуулалттай орнуудад үйлдвэрлэсэн байх
 2. ISO -н шаардлага хангасан байх.
 3. Ердийн нөхцөлд өөрийн савалгаанд хадгалах боломжтой байх
 4. жирэмслэлтээс сэргийлэх хэрэгслийн хүчинтэй байх хугацаа нь нийлүүлэх үед 2 жилээс дээш хадгалах хугацаатай байх

2.Стандарт: Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ

3.Баглаа, боодол: [Нийлүүлэгч нь захиалагчийн хуваарийн дагуу техникийн нөхцөл шаардлагыг хангасан эм барааг нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан падан, нэхэмжлэх, е-баримтыг 15 эрүүл мэндийн төвийн нэр дээр бичиж эм бараатай хамт Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.]

4.Бараа хүргэх газар: [Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газар 1 давхар 115тоот]

5.Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) **1) Нийлүүлэгч нь захиалагчийн хуваарийн дагуу техникийн нөхцөл шаардлагыг хангасан эм барааг нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан падан, нэхэмжлэх, е-баримтыг 15 эрүүл мэндийн төвийн нэр дээр бичиж эм бараатай хамт Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.**
2) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ
5) Барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. / хадгалах хүчинтэй хугацаа/
1. Нийлүүлэгдэх жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслийн хүчинтэй байх хугацаа нь нийлүүлэх үед 2 жилээс дээш хадгалах хугацаатай байна.
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
1. Нийлүүлэгч нь барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан зарлагын баримт, нэхэмжлэх, е-баримтыг гэрээнд заасан нийлүүлэлтийн хуваарийн дагуу 15 эрүүл мэндийн төвийн нэр дээр ирүүлэх бөгөөд ЭМТ-д тухайн баримтыг үндэслэн төлбөрийг хийнэ.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² а. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
Алдангийн нийт дүн: **[тоо]**

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

ЗАХИАЛАГЧ	ХЭРЭГЛЭГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)	(Гарын үсэг)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ДАРГА

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
Ц.ӨНӨРЖАРГАЛ
2019 оны 05 сарын 24 өдөр

Өмнөговь аймгийн сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгсэл нийлүүлэх ажлын техникийн нөхцөл

Д/д	Жирэмслэлтээс сэргийлэх аргын нэр	Эм, хэрэгслийн нэр	Тун хэмжээ, хэлбэр	хэмжих нэгж	Шаардлага тай тоо хэмжээ	Техникийн ерөнхий нөхцөл
1	Жирэмслэлтээс сэргийлэх тариа	Медроксипрогестрон	тарилгын уусмал 150мг/мл + тариурын хамт, тариурын зүү 22G	фл	1,795	1. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байх 2. ДЭМБ-н эсвэл НҮБХАС-н урьдчилсан баталгаажуулалтад хамрагдсан байх, эсвэл эмнэлгийн хэрэгслийн хувьд хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй байх 3. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон байх 4. Эм үйлдвэрлэлийн зохистой дадалын /GMP/ шаардлагыг хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн 5. Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан байх 6. жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслийн хүчинтэй байх хугацаа нь нийлүүлэх үед 1,5 жилээс дээш хадгалах хугацаатай байх
2	Жирэмслэлтээс сэргийлэх суулгац	Левногестрол 75мг №2	Левногестрол 75мг-150мг суулгац, тавих тракорын хамт	багц	210	
3	Жирэмслэлтээс сэргийлэх дааврын хавсарсан эм	Левногестрол 0.15мг+этинилэстриадиол 0.03мг + феррум 75мг	Левногестрол 0.15мг +этинилэстриадиол 0.03мг, +феррум 50-100мг 28-30 хоногийн мөчлөг бүхий савлагаатай бүрхүүлтэй шахмал	№28	2,545	
4	Жирэмслэлтээс сэргийлэх хэрэгсэл	Эрэгтэй бэлгэвч	50-52мм, чийгшүүлэгчтэй	ширхэг	13,100	
5		Ерөндөг	Т хэлбэрийн, зэс агуулсан, хөтлөгчийн хамт нэг нэгээрээ савлагдсан	ширхэг	195	
6		Ерөндөг /Охидын/	хөтлөгчийн хамт нэг нэгээрээ савлагдсан / IUD CU-375-тай дүйцэхүйц/	ширхэг	135	
7		Жирэмсний хурдавчилсан сорил	Шээсэнд HCG тодорхойлох түргэвчилсэн тест нэг нэгээрээ савлагдсан	ширхэг	245	

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ДАРГА



БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
Ц.ӨНӨРЖАРГАЛ
2019 оны 05 сарын 24 өдөр

СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД ШААРДЛАГАТАЙ ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

Д/Д	Эм, хэрэгслийн нэр	Тун хэмжээ, хэлбэр	хэмжих нэгж	Шаардлагатай нийт тоо	Шаардлагатай тоо хэмжээ														
					1.Баяндалай СЭМТ	2.Баян-Овоо СЭМТ	3.Булган СЭМТ	4.Гурвантэс СЭМТ	5.Мандал-Овоо СЭМТ	6.Манлай СЭМТ	7.Номгон СЭМТ	8.Сэврэй СЭМТ	9.Ханхонгор СЭМТ	10.Хүрмэн СЭМТ	11.Цогт-Овоо СЭМТ	12.Өнө-Орших ӨЭМТ	13.Шимбилэг ӨЭМТ	14.Энхийн хүслэн ӨЭМТ	15.Энэрхүй - Ухаан ӨЭМТ
1	Медроксипрогестрон	тарилгын уусмал 150мг/мл + тариурын хамт, тариурын зүү 22G	фл	1,450	35	40	45	150	40	45	45	40	65	40	60	220	225	250	150
2	Левногестрол 75мг №2	Левногестрол 75мг-150мг суулгац, тавих тракорын хамт	багц	210	10	5	0	10	5	10	5	10	15	5	5	20	55	35	20
3	Левногестрол 0.15мг+этинилэстриадиол 0.03мг + феррум 75мг	Левногестрол 0.15мг +этинилэстриадиол 0.03мг, +феррум 50-100мг 28-30 хоногийн мөчлөг бүхий савлагаатай бүрхүүлтэй шахмал	№28	2,370	95	80	120	255	60	80	150	110	100	80	85	350	250	310	245
4	Эрэгтэй бэлгэвч	50-52мм, чийгшүүлэгчтэй	ширхэг	12,700	1000	800	1000	1600	550	1300	1400	150	550	200	150	1000	1000	2000	

5	Ерөндөг	Т хэлбэрийн, зэс агуулсан, хөтлөгчийн хамт нэг нэгээрээ савлагдсан	ширхэг	115	10	20	0	20	10	0	0	0	0	0	25	10	20	0	
6	Ерөндөг /Охидын/	хөтлөгчийн хамт нэг нэгээрээ савлагдсан / IUD CU-375-тай дүйцхүйц/	ширхэг	140	10	10	5	5	10	5	5	10	5	5	15	20	15	20	
7	Жирэмсний хурдавчилсан сорил	Шээсэнд HCG тодорхойлох түргэвчилсэн тэст нэг нэгээрээ савлагдсан	ширхэг	235	20	10	10	20	10	20	10	10	10	10	0	40	35	15	15

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС